

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2014 оны 2 дугаар сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2014 оны 2-р сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1150 болж, 2013 оны мөн үеэс 49 хүнээр өсч, өмнөх сарынхаас 134 хүнээр буурав.

Ажилгүйчүүдийн 53,56 хувь буюу 616 нь эмэгтэйчүүд юм. 2014 оны эхнээс 148 ажлын байр захиалгад бүртгэгдсэнээс 43 ажлын байранд иргэд зуучлагдан ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 30,23 хувь буюу 13 нь эмэгтэйчүүд байна.

Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 2 дугаар сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 145 ажилгүй иргэний 42,8 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 26,9 хувь нь сургууль төгссөн, чөлөө авсан; 15,2 хувь нь одоо эрхэлж буй ажлаа солих хүсэлтэй байгаа, 4,8 хувь нь өөр газраас шилжин ирсэн; 2,8 хувь нь орон тооны цомхтголд орсон; 2,1 хувь нь гадаадаас эргэж ирсэн; тус бүр 1,4

хувь нь байгууллага татан буугдсан, гүйцэтгэж буй ажил албан тушаалдаа тэнцэхгүй болсон шалтгаанаар; 0,7 хувь нь хорих газраас суллагдсан; 2,1 хувь нь бусад шалтгаанаар бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын төвшинээр хуваавал 21,4% нь дээд; 9,8% нь тусгай дунд; 10,1% нь мэргэжлийн анхан шатны; 38,3% нь бүрэн дунд; 16,1% нь бүрэн бус дунд боловсролтой; 4,3% нь бага буюу боловсролгүй иргэд юм.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2014 оны 2 дугаар сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 2 сард НДШ-ийн орлого 2007.2 сая ₮ болж төлөвлөгөө 92.26 хувь болж, төлөвлөгөөг Баянжаргалан, Баянчандмань, Жаргалант, Заамар, Зуунмод

сумд 11.9-17.1 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 99,63 сая ₮ болж төлөвлөгөө 129,87 хувиар бүх сум давуулан биелүүллээ.

Тэтгэвэр, тэтгэмжинд 4741,2 сая ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 81,0 хувийг өндөр настны, 10.0 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4,0 хувийг тэжээгчээ алдсаны, 5.0 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 218332 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 29.15% хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 22.5%; тэтгэмжийн даатгалын сангийн 86.7%; эрүүл мэндийн даатгалын сангийн 56.4%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 138.08%; ажилгүйдлийн даатгалын сангийн 132.5%-ийг тус бүр бүрдүүлжээ.




1.3 Эрүүл мэнд

2014 оны эхний 2 сард 2785 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэ гөвчтөнд дунджаар 7.9 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 2 сард 220 хүүхэд мэндэлсэн нь 2013 оны мөн үеэс 38 хүүхдээр өслөө. Зураг 1.3

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар



Аймгийн хэмжээнд 2014 оны эхний 2 н сард нялхсын эндэгдэл гараагүй ба өмнөх оны мөн үеийнхээс 1-ээр байна. Зураг 1.4


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар



2014 оны эхний 2 сард нийт гарсан халдварт өвчнөөр 70 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 44.4 хувь буюу 56 хүнээр буурлаа. 2013 оны мөн үеэс бусад өвчлөл 4.7 дахин, трихомениаз 1 дахин тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 8 байгаа бол: Зуунмод 26, Сүмбэр 22, Дэлгэрхаан 13, Баян-Өнжүүлд 10 ногдлоо.

Зураг 1.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар



2014 оны 2 дугаар сарын цаг агаарын урьдчилсан төлөв.

Төв аймгийн нутгаар. Энэ сарын агаарын температурын дундаж нь 15-20 градус хүйтэн буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй. Хүйтрэх үе Нэг ба гуравдугаар арав хоногийн эхний хагас, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар хүйтний эрч чангарч голын хөндийгөөр шөнөдөө 31-36, өдөртөө 17-22 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 23-28, өдөртөө 13-18 градус хүйтэн. Хүйтний эрч нилээд сулрах үе Нэг ба гуравдугаар арав хоногийн сүүлчээр томоохон голын хөндийгөөр шөнөдөө 19-24, өдөртөө 6-11 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 14-19, өдөртөө 1-6 градус хүйтэн. Бусад хугацаанд Томоохон голын хөндийгөөр шөнөдөө 23-28, өдөртөө 10-15 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 18-23, өдөртөө 6-11 градус хүйтэн. Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Төв аймгийн баруун өмнөд болон зүүн хойд хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас ахиу орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр бага

зэргийн цас орно. Хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр ихэнх нутгаар, гуравдугаар арав хоногийн эхээр зарим газраар цас орно. Энэ үеүдэд зарим нутгаар салхи баруун хойноос 12-14 м/с, ялангуяа хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлч, гуравдугаар арав хоногийн эхээр нутгийн өмнөд хэсгээр 16-18 м/с хүртэл ширүүсч цасан болон шороон шуурга шуурах төлөвтэй.




1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 2 сард аймгийн хэмжээнд 168 гэмт хэрэг бүртгэгдэж 112 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 514.6 сая төгрөгийн хохирол учирлаа.

Зураг 1.6

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 2 дугаар байдлаар



Гарсан гэмт хэргийн 39.9 хувь нь хулгай, 26.2 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний хэрэг, 11.3 хувь нь бусад хэрэг, 16.7 хувь нь замын осол, 4.8 хувь нь танхай дээрэм, 1.2 хувь нь хүн амины хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Баяндэлгэр, Баянхангай, Цээл, Баян сумдад 10000 хүнд 35-54 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (19) харьцангуй их байна.

Зураг I.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Гэмт хэргийн тоо 2013 оны мөн үеэс 54 хэргээр өслөө.


Зуунмод суманд 6 эмэгтэй, 179 эрэгтэй нийт 185 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оны мөн үеэс 49 хүнээр өслөө.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2014 оны эхний 2 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 813 гүйцэтгэх хуудсанд нийт 1435.5 сая ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 9 гүйцэтгэх хуудсанд ногдох 18.6 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 804 гүйцэтгэх хуудасны 112.9 сая ₮-өөс 87 хуудасны 112.9 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудсны тоогоор 10.82 хувь, үнийн

дүнгээр 7.97 хувь болж 2013 оны мөн үеэс гүйцэтгэх хуудсны биелэлт 2,38 нэгжээр буурч, үнийн дүнгийн биелэлт 0.46 нэгжээр өслөө.




II. Эдийн засгийн үзүүлэлт



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2014 оны 2-р сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 41,77%, өмнөх оны мөн үеэс 12.88%, өмнөх сараас 0.34 хувиар тус тус өсөв. 2 дугаар сард өмнөх сартай харьцуулахад нийт өрхийн хүнсний хэрэглээнд өндөр хувийн жин эзэлдэг согтууруулах бус ундааны дэд бүлэг 2,33%, мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 1,17%-аар, усан хангамж болон орон сууцны бусад үйлчилгээний дэд бүлэг /орон сууцны дулаан, сөх-ийн үнэ/ 7,80%-аар тус тус өсөв.

Зураг II.4 Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хэрэглээний үнийн индексийн 2014 оны 2 дугаар сарын 0,34 хувийн өсөлтийн 0,2 нэгж (58,4%) нь тээврийн бүлгийн үнийн өсөлтөөс; 0,12 нэгж (34,83%) нь амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс; 0,08 нэгж (23,08%) нь эм, тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөстус тус шалтгаалсан байна.

Зураг II. 5


Инфляцийн өсөлтөд үзүүлсэн бүлгүүдийн нөлөөлөл

Бараа, үйлчилгээний бүлэг	2014 оны 2-р сард	
	пунктээр	хувиар
Бүгд	0,34	100,00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	-0,07	-19,73%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0,00	0,00%
03. ХУВЦАС, БЭС БАРАА, ГУТАЛ	-0,06	-18,41%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0,04	11,64%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0,00	0,34%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0,08	23,08%
07. ТЭЭВЭР	0,20	58,35%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0,00	0,00%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0,12	34,83%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0,00	0,00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0,00	0,00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0,03	9,90%

II. Төл бойжилт

4 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 26.39 хувь 422.74 мянган хээлтэгч мал төллөж,

430.86 мянган төл гарсны 99.62 хувь 429.22 мянган төл бойжиж байгаан урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 47.5 хувь буюу 136.18 мянгаар; бойжиж буй төл 51.08 хувь 145.13 мянгаар тус бүр өслөө.



Оны эхний төллөх насны ингэний 5.09; гүүний 3.05; үнээний 10.60; эм хонины 28.25; эм ямааны 29.97 хувь нь тус бүр төллөв. Гарсан төлийн 0.38 хувь 1643 болох толгой төл хорогдсон нь урьд оны мөн үеэс 1.2 дахин буюу 2002 төлөөр буурлаа. Гарсан унаганы 1.19, тугалын 0.73, хурганы 0.24, ишигний 0.55 хувь нь тус бүр хорогдов.

Бойжуулсан төлийн тоо, төрлөөр, аймгийн дүнгээр

	МЯН.ТОЛ				
	2010	2011	2012	2013	2014
Бүгд	240.00	278.78	343.36	284.09	429.22
Тэмээ	0.03	0.03	0.11	0.08	2.65
Адуу	2.78	0.42	3.87	1.23	10.29
Үхэр	5.50	2.90	7.78	5.22	0.05
Хонь	145.11	159.99	189.80	166.01	243.78
Ямаа	86.59	115.45	141.80	111.55	172.44

Том малын зүй бус хорогдол

2014 оны 4 сарын 1-ний байдлаар оны эхний малын 0.13 хувь буюу 4569 том мал зүй бусаар хорогдсон нь 2013 оны мөн үеэс 1.48дахин буюу 6782 толгойгоорбуурлаа.

Зүй бусаар хорогдсон том малын тоо, төрлөөр, аймгийн дүнгээр жил бүрийн эхний улиралд, мян толгой

	2010	2011	2012	2013	2014
Бүгд	344165	5409	5268	11351	4569
Тэмээ	25		1	1	2
Адуу	16377	482	520	585	439
Үхэр	16979	486	435	764	382
Хонь	141513	2216	2002	4550	1873
Ямаа	169271	2225	2310	5451	1873



II.5 Аж үйлдвэр

2014 оны эхний 2 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 1403.97 сая₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2013 оны мөн үеэс 65.7 хувь буюу 556.86 сая₮-өөрөслөө. Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Зуунмод, Баянцогт, Эрдэнэ, Батсүмбэр, Борнуур сумд 61.05-3.44 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 78.03) хувийг эзлэв.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр


АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, мян төг
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2013 II	2014 II	2013 I-II	2014 I-II	Дүнч зэлэх % Percentage share to total		2014% 2013%
					2013 I-II	2014 I-II	
Нийт дүн	384.38	0.00	847.11	0.00	100.0	100.0	162.2%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	5.25	7.85	12.30	11.35	15.68%	27.63	285.9%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	69.10	0.00	254.02	0.00	42.18	52.16	200.7%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	310.03	0.00	580.79	0.00	42.1	20.20	77.8%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөний архи, ундаа үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл 2013 оны мөн үеэс 4.9 дахинаас-7.3 хувиар буюу 365.0-4.43 сая₮-өөр өссөн нь нөлөөлөв.


Зураг II.6

Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны эхний 2 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 31.85, боловсруулах үйлдвэрлэл 67,34, уул уурхайн үйлдвэрлэл 0.81 хувийг тус тус эзлэв.

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар, хувиар





II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлогооны эхний 2 сард 38.9 сая₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 19.8 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1 дахин буюу 21.1 сая₮-өөрөслөө.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 14.6 сая₮ болж, нийт орлогын 79.3 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт орлогын 20.69 хувийг албан бичгийн, 16.37 хувийг зорчигчдын, 62.94 хувийг бусад орлого эзлэв.

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр

